

МОНГОЛ, БРИТАНИЙ ХАРИЛЦААНЫ ШИНЭ ХАНДЛАГА

*Д.Золбоо**

2003 онд Монгол, Британий хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг хоёр талд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн билээ. Өнгөрсөн 4 жилийн дотор хоёр талын харилцаанд олон нааштай өөрчлөлтүүд гарч хоёр талын харилцаа улам бүр идэвхтэйгээр өргөжин тэлсээр байна.

Тэр дундаа энэ оны эхний хагас хоёр талын харилцааны түүхэнд тэмдэглэгдэн үлдэх олон онцлог үйл явдлаар дүүрэн байлаа. Үүнд юуны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Британий Ерөнхий сайд Тони Блэйрийн урилгаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад 2007 оны 4 дүгээр сарын 16-18-нд хийсэн албан ёсны айлчлалыг нэрлэх нь зүйтэй билээ. Энэхүү айлчлал нь Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын ИБУИИНВУ-д 1996 онд хийсэн албан ёсны айлчлалаас хойш манай талаас төрийн тэргүүний түвшинд хийгдсэн хоёр дахь айлчлал байснаараа онцлог гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Манай төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Сангийн сайд Н.Баяртсайхан, УИХ-ын гишүүн Монгол, Британий Парламентийн бүлгийн дарга Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн С.Оюун, Р.Рааш, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр, Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Т.Билэгт, Төрийн өмчийн хорооны дарга Т.Сугар, Байгаль орчны дэд сайд О.Энхмандах, Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Цогтбаатар, Л.Лхагва нарын хүмүүс багтсан байна. Мөн манай хэвлэл, мэдээллийн томоохон сурвалжлах хэсэг болон бизнесийн төлөөлөгчдийн баг дагалдан явжээ.

Айлчлалын үндсэн зорилго нь Монгол, Британийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, найрсаг харилцаа, хамтын ажиллагаанд түлхэц өгөх, Монгол Улсын олон улсын байр суурь, нэр хүндийг нэмэгдүүлэхэд оршиж байв. Монгол Улсын Төрийн тэргүүн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, Европын Холбоо, НАТО-гийн нөлөө бүхий гишүүн орон болох Британид ийнхүү албан ёсны айлчлал хийсэн нь өндөр хөгжилтэй, ардчилсан улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой алхам болсон.

Ерөнхийлөгч айлчлалынхаа хүрээнд Британийн Ерөнхий сайд Тони Блэйртэй хэлэлцээ хийж, Засгийн газрын гишүүн, Нийтийн танхимын тэргүүн Жак Струу, Засгийн газрын гишүүн, Худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн сайд Иан Маккартни,

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Британийн Парламент дахь Монголын бүлгийн дарга Ж.Гроган болон албаны бусад хүмүүстэй албан ёсны уулзалт хийжээ.

Айлчлалын үеэр Британийн болон дэлхийд нэр хүндтэй уул уурхай, боловсруулалт, хөрөнгө оруулалт, банк, санхүүгийн чиглэлийн тэргүүлэх компаниудын нэг болох “Рио Тинто” компани болон Монголтой хамтран ажилладаг Британийн болон бусад орны уул уурхайн салбарын томоохон хөрөнгө оруулагчидтай тухайлбал Фортескью металс, Арселор Митталс мөн санхүүгийн HSBC, CITIGROUP-ийн удирдлагатай уулзаж Монгол Улсын Үндэсний Хөгжлийн цогц бодлоготой уялдуулан харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар санал солилцжээ. Мөн Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтын ажиллагааны асуудлаар ярилцав.

Мөн тэрээр Оксфордын Их сургуулийн Монгол Улсын гадаад бодлогын асуудлаар лекц уншиж, сонирхсон асуудлаар харилцан ярилцсан бөгөөд тус сургуулийн салбар сургууль болох Волфсон коллежид зочилж, Хатан хааны Олон улс судлалын “Chatham House”-д Британийн эрдэмтэд, судлаачидтай уулзалт хийжээ. Мөн Монгол, Британийн бизнес эрхлэгчдийн уулзалтад оролцон үг хэлж, өөрийн элчин сайдын яамны байранд Британид оршин суугаа монгол иргэдийн төлөөлөгчидтэй уулзаж ярилцсан байна. Айлчлалын үеэр BBC-гийн “Radio 4” мөн “Reuters”, “Sky TV”, “Bloomberg”, “FIRST” сэтгүүл зэрэг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шууд болон дэлгэрэнгүй ярилцлага өгсөн байна. Британий талаас голлон сонирхож байсан сэдэв нь Монгол Улсад өрнөж байгаа уул уурхайн үйлдвэрлэлийг тойрсон элдэв асуудлуудын талаар ерөнхийлөгчийн албан ёсны байр суурийг тодруулахад чиглэж байлаа.

Монголын төвийн тогтмол сонин хэвлэлээр төрийн тэргүүний айлчлалын талаар нэлээд дэлгэрэнгүй мэдээлсэн боловч зарим нэгэн шүүмжлэлтэй өнгө аястай мэдээлэл ч багагүй гарсан бөгөөд “өөрт тэр бүр хамааралгүй засгийн газрын ажилд хэт оролцсон”, “улс төр болон шашны асуудлуудыг хамруулсан” зэрэг шүүмжлэлд өртөж байлаа. Тухайлбал, “Улаанбаатар хотод суурилуулах өндөр өртөгтэй замын хяналтын систем”, “Оксфордын Их сургуульд уншихаар төлөвлөсөн шашны лекц”, “Социалист интернационалын Ерөнхий нарийн бичгийн даргатай хийсэн уулзалт” зэргийг дурьдаж болох юм. Хэдий тийм боловч хоёр тал айлчлалын үр дүнд сэтгэл хангалуун байгаагаа албан ёсоор илэрхийлсэн билээ.

Айлчлалын үеэр албан ёсоор дараах баримт бичгүүдийг байгуулжээ. Үүнд:

- Айлчлалын асуудлаарх хамтарсан мэдэгдэл

- Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газар, ИБУИНВУ-ын Asia House байгууллага хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг

- Монгол Улсын Байгаль орчны яам, Лондонгийн амьтан судлалын хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг зэрэг юм.

Харин энэхүү айлчлалаас хойш сар гаруйхны дараа Британий талаас ИБУИНВУ-ын Йоркийн гүн, Ханхүү Эндрю Монгол Улсад 2007 оны 6 дугаар сарын 1-нээс 3-ны өдрүүдэд ажлын айлчлал хийв.

Ханхүү Эндрю 6 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхаж, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтын салбарын хамтын ажиллагааны асуудлаар ярилцав. Мөн тэрээр Сангийн сайд, Үйлдвэр худалдааны дэд сайд нартай уулзав. Албаны хүмүүстэй хийсэн уулзалт, ярианы гол сэдэв нь Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, тэр дундаа уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдыг татах таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн ажээ.

Ханхүү Эндрю 6 дугаар сарын 2-ны өдөр Өмнөговь аймаг дахь Оюутолгой төслийн газар дээр очин үйл ажиллагаатай өөрийн биеэр танилцжээ. Түүний айлчлалын талаар дэлгэрэнгүй мэдээллийг одоогоор олж үзэх бололцоогүй байгаа бөгөөд хэсэг хугацааны дараагаар тодорхой болох бизээ.

Энэхүү үйл явцыг нэгтгэн үзвэл манай 2 орны харилцаа хоёр талдаа харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр хамтран ажиллах талаар өргөжин тэлэх хандлагатай байгааг харж болно. Тиймээс тус хүрээлэнгийн Европ, Америк судлалын тасгийн судалгааны ажлын нэгээхэн хэсэг нь ИБУИНВУ зэрэг хөгжлийн өндөр төвшинд хүрсэн улс орнуудаас оруулж буй хөрөнгө оруулалт, эдийн засаг, улс төрийн харилцааны цаашдын төлөв, хандлагад чиглэгдэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ГХЯ-ны “Гадаад харилцаа” мэдээллийн товхимол, 2007 оны 5 дугаар сар
- “Өнөөдөр”
- “Зууны мэдээ”
- “Өдрийн сонин”
- <http://www.oloo.mn/modules.php?name=News&file=article&sid=53917&catid=227>
- <http://www.oloo.mn/modules.php?name=News&file=article&sid=54419&catid=227>